МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/94 Мандалговь

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2020 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.17 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 9.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 12.1, 12.6, 13.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 5 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн дүнг нэгдүгээр хавсралтаар, агентлагийн үйл ажиллагаанд анхаарах нийтлэг зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн нийтлэг хэрэгжүүлэх зөвлөмж, Хяналт -шинжилгээний үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт үр дүнг тооцон зөвлөмжийн хэрэгжилтийг 6, 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст тайлагнахыг хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээгээр “Санаачилгатай сайн” дүгнэгдсэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, болон хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нарт 1 сарын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг төсөвтөө багтаан олгохыг агентлагийн дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагуудад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавихыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Самданцоодол)-т, агентлагуудын үйл ажиллагаанд зөвлөн тусалж, үр дүнг дээшлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210261

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
09 –ны өдрийн А/ѕѕ тоот захирамжийн 01 дүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГУУДЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ**

| № | Хэлтэс, агентлагийн нэр | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт | | Дундаж | Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт | | | | | Дундаж | Байгууллагын нээлттэй байдал | | Дундаж | Ерөнхий үнэлгээ | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт | | Яамдын сайд нартай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний агентлаг хамааралтай заалтын биелэлт | Аймгийн Засаг даргатай агентлагийн | Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын | Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт | Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт | | Байгууллагын ил тод байдлын үнэлгээ | Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтөлтийн үнэлгээ | | | |
| 1 | ГХБХБГ | 90 | 92.25 | **91.1** | 93.8 | 99.6 | 97 | 100 | 98.3 | **97.7** | 100 | 98.6 | **99.3** | **96.05** | Санаачилгатай |
| 2 | ОБГ | 97.5 | 94 | **95.8** | 92.5 | 96.1 | 97 | 96.5 | 91.5 | **94.7** | 95.4 | 99.6 | **97.5** | **95.99** | Санаачилгатай |
| 3 | БОАЖГ | 91.8 | 95.5 | **93.7** | 96.0 | 98.9 | 100 | 87.6 | 94.6 | **95.4** | 100 | 93.3 | **96.7** | **95.24** | Санаачилгатай |
| 4 | МХГ | 96.7 | 89 | **92.9** | 92.5 | 98.1 | 93.2 | 90 | 92.3 | **93.2** | 100 | 98.6 | **99.3** | **95.12** | Санаачилгатай |
| 5 | ЦГ | 97.3 | 90.1 | **93.7** | 100.0 | 92.0 | 97 | 98.2 | 91.7 | **95.8** | 92 | 98.2 | **95.1** | **94.86** | Санаачилгатай |
| 6 | ХХҮГ | 90 | 92.5 | **91.3** | 82.6 | 89.3 | 97 | 95 | 98.0 | **92.4** | 100 | 99.3 | **99.7** | **94.43** | Санаачилгатай |
| 7 | УЦУОШТ | 90.6 | 95 | **92.8** | - | 90.0 | 94 | 98.4 | 89.2 | **92.9** | 95 | 100 | **97.5** | **94.40** | Санаачилгатай |
| 8 | СХ | 90 | 92.8 | **91.4** | - | 94.3 | 83.2 | 94 | 91.0 | **90.6** | 100 | 98 | **99.0** | **93.68** | Санаачилгатай |
| 9 | БСҮГ | 86 | 92.8 | **89.4** | 91.0 | 90.3 | 96.2 | 91.6 | 82.4 | **90.3** | 96.4 | 99.7 | **98.1** | **92.58** | Санаачилгатай |
| 10 | ШШГГ | 84 | 84.6 | **84.3** | 70.0 | 91.5 | 92.5 | 100 | 89.2 | **88.6** | 95 | 98 | **96.5** | **89.81** | Хэвийн |
| 11 | ЭМГ | 91 | 88 | **89.5** | 92.8 | 90.0 | 97 | 88 | 72.6 | **88.1** | 85.8 | 95 | **90.4** | **89.33** | Хэвийн |
| 12 | ШШАлба | 90 | - | **90.0** | 90.2 | 70.0 | 93 | 100 | 76.6 | **86.0** | 91.3 | 92.6 | **92.0** | **89.30** | Хэвийн |
| 13 | ТХ | 87 | - | **87.0** | 70.0 | 93.1 | 93.2 | 97.2 | 72.5 | **85.2** | 91.2 | 100 | **95.6** | **89.27** | Хэвийн |
| 14 | ОНӨГ | 87.5 | - | **87.5** | 100.0 | 93.3 | 89.5 | 100 | 78.0 | **92.2** | 86.3 | 88 | **87.2** | **88.94** | Хэвийн |
| 15 | ХХААГ | 75 | 86.8 | **80.9** | 82.6 | 96.8 | 93 | 97.7 | 81.6 | **90.3** | 90 | 100 | **95.0** | **88.75** | Хэвийн |
| 16 | НДХ | 85 | - | **85.0** | 81.1 | 94.9 | 90.7 | 100 | 81.8 | **89.7** | 78.7 | 100 | **89.4** | **88.02** | Хэвийн |
| 17 | МЭГ | 70 | 94.1 | **82.1** | 92.5 | 98.7 | 83.25 | 96.8 | 75.1 | **89.3** | 84.6 | 98.6 | **91.6** | **87.64** | Хэвийн |
| 18 | ГБХЗХГ | 96.1 | 88 | **92.1** | 82.9 | 90.0 | 93.7 | 80.4 | 77.8 | **85.0** | 88.7 | 80 | **84.4** | **87.12** | Хэвийн |
| 19 | УБХ | 86 | 90 | **88.0** | 85.0 | 97.0 | 83 | 100 | 88.5 | **90.7** | 70 | 94.6 | **82.3** | **87.00** | Хэвийн |
| 20 | СХАА | 80 | - | **80.0** | 100.0 | 96.2 | 75.25 | - | 79.4 | **87.7** | 82.5 | 95.3 | **88.9** | **85.54** | Хэвийн |
| 21 | СХЗХ | 89.5 | 70 | **79.8** | 93.8 | 85.0 | 75.3 | 91.5 | 75.5 | **84.2** | 86.3 | 94 | **90.2** | **84.71** | Хэвийн |
| 22 | БТСГ | 80 | 70 | **75.0** | 82.7 | 82.5 | 91.25 | - | 80.4 | **84.2** | 70.8 | 94.6 | **82.7** | **80.64** | Хэвийн |
| | **ДҮН** | **87.8** | **88.6** | **87.9** | **88.6** | **92.2** | **91.1** | **95.1** | **84.5** | **90.2** | **90.0** | **96.2** | **93.1** | **90.38** | |